

БАТЛАВ  
 МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
 Я.СОДБААТАР  
 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ, ӨДӨРЛӨГИЙН ХУВААРЬ

А/А	Нэгдсэн арга хэмжээний нэр		2021 он											
			1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
1	"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагааг, ам эхгүйн нэгж, байгууллага айл өрхийн тал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээ	Хамтран ажиллах байгууллага	[Red]											
2	Өвөлжилт, хаваржилт хундрах болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ		[Dark Blue]									[Dark Blue]		
3	Шар усны үеэрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ				[Yellow]									
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ							[Green]						
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таныулах өдөрлөг				[Blue]									
6	Гэмшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөрлөг												[Purple]	
7	Олон улсын Иргэний хамгаалалтын өдөрлөг				[Dark Blue]									

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН АЖЛЫН АЛБА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨХИРҮҮЛГЭГЧ АГЕНТЛАГ  
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Парламент гудамж, Утас: 26 35 04, Факс: (975-11) 32 40 77,  
И-мэйл: dsc@nema.gov.mn, Вэбсайт: www.nema.gov.mn

2020.12.17 № 2/2739

талай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.ЖАРГАЛ ТАНАА**

Монгол Улсын Шадар сайдаар батлуулах  
"Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын  
тогтвортой ажиллагааг, аж ахуйн нэгж,  
байгууллага, айл өрхийн гал түймрийн аюулгүй  
байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээний  
удирдамж, төлөвлөгөөг боловсруулж байна.

Төлөвлөгөөнд тусгах ажлаа хавсралтын  
дагуу гаргаж, Гамшгаас урьдчилан сэргийлэх  
газрын мэргэжилтэн, дэслэгч Б.Энхмаагийн  
Enkhmaalenma4@gmail.com цахим хаягаар 2020  
оны 12 дугаар сарын 21-ний өдрийн дотор ирүүлж,  
хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт 1 хуудастай.

Хүндэтгэсэн.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА  
ХУРАНДАГ ~~Д.ЖАРГАЛ ТАНАА~~ Ж.ЦУЛТЭМСҮРЭН



0003185

D:\2020\3\_4r ultra\A-5-2020-3\_4.docx



**ЭРЧИМ ХҮЧ, УС ДУЛААН ХАНГАМЖИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ  
АЖИЛЛАГАА, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЙЛ ӨРХИЙН ГАЛ ТҮЙМРИЙН  
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго**

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулаан, усны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төрөөс хариуцахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулж аж ахуй нэгж, байгууллага, айл өрхүүдэд цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны зохиомол өндөр хэрэглээ үүсч улмаар стратегийн онц чухал объектуудын тогтвортой ажиллагаа алдагдах, гал түймэр, үйлдвэрлэлийн ослын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэдэд арга зүйн зөвлөмж хүргэхэд оршино.

**Хоёр. Ерөнхий зүйл**

2.1. Төрийн хяналт, шалгалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Эрчим хүчний тухай хууль, Улсын Их Хурлын 2011 оны 22 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, мэргэжлийн байгууллагаас гаргасан норм норматив нь эрх зүйн үндэс болно.

2.2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад дээрх хууль тогтоомж, энэхүү удирдамж, түүний хавсралт төлөвлөгөөг баримтлан ажиллана.

2.3. Энэхүү нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийслэл, орон нутгийн аж ахуйн нэгж байгууллага, гэр хорооллын айл өрхүүдийн цахилгаан эрчим хүч, ус, дулаан ашиглалт, зохистой хэрэглээ, галын аюулгүй байдлыг хангах хяналт шалгалт, ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

**Гурав. Нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсэг**

3.1. Эрчим хүчний яамнаас:

- Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат

3.2. Онцгой байдлын ерөнхий газраас:

- Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн дарга, хурандаа Д.Баян-Эрдэнэ

- Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ

- Төв, орон нутгийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс, тасаг, хяналтын байцаагч, мэргэжилтэн

3.3. "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-иас:

- Хяналтын инженер Г.Магсаржалам,

- Гамшгийн асуудал хариуцсан инженер Э.Дагвадорж,

3.4. "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-иас:

- Ажлын байрны эрүүл ахуй, онцгой байдал хариуцсан мэргэжилтэн Н.Мөнхбаяр,

3.5. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас:

- Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч Б.Мөнхсайхан,
- Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Б.Эрхэмбаяр,
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа бүтцийн нэгж

3.6. "Ус сувгийн удирдах газар" НААТҮГ-аас:

- Цэвэр усны горим тооцооны инженер Р.Атаржаргал,
- Инженерийн бодлогын хэлтэс.

Ажлын хэсгийн нэрийн бичиг нь Онцгой байдлын ерөнхий газраас байх бөгөөд хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд мэдээллээ ОБЕГ-т ирүүлнэ.

Нийслэл, орон нутагт энэхүү удирдамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын орлогчоор ахлуулан орон нутгийн онцлогт нийцүүлэн удирдамж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

#### **Дөрөв. Хугацаа, хамрах хүрээ**

4.1. "Эрчим хүч, ус дулаан хангамжийн салбарын тогтвортой ажиллагаа, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах" нэгдсэн арга хэмжээг 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулна.

4.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ард иргэдийн аюулгүй байдал, аж ахуйн нэгж, байгууллагын түлш эрчим хүч, ус, дулаан хангамж, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, зүй зохистой хэрэглээ, галын аюулгүй байдал хамаарна.

#### **Тав. Хяналт шалгалтын ажлын хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагаа**

5.1. Эрчим хүчний үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагуудын ашиглалтын үйл ажиллагаанд үзлэг хийж, зөвлөн туслах.

5.2. Эрчим хүчний барилга байгууламжийн техник, ашиглалт, аюулгүй ажиллагааг хангуулах, цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн ачаалал огцом нэмэгдэх, шугам сүлжээ, дэд станцуудад эвдрэл, гэмтэл гарах зэрэг эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.

5.3. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахилгаан дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах.

5.4. Хэт ачаалал үүсч болзошгүй шугам тоноглолын үзлэг шалгалтыг тогтмол хийж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

5.5. Гэр хорооллын айл өрхийн оруулгын утсанд цахилгааны болон галын аюулгүй байдалд үзлэг шалгалт хийх.

5.6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторк, зурагт постерыг шинээр хийж олон нийтэд хүргэх

5.7. Гал түймрийн нөхцөл байдал, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, холбогдох мэргэжилтнүүдийг телевиз, сонины ярилцлагад оролцуулах.

5.8. Аж ахуйн нэгжүүдийн цахилгаан байгууламжид болон галын аюулгүй байдалд үзлэг шалгалт хийх мэдэгдэл шаардлага өгөх.

5.9. Улсын хэмжээнд усан халаалтын зуухны үйлдвэрлэл, угсралтын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААН-ийн үйл ажиллагаанд шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

5.10. Дулаан, ус зэрэг инженерийн шугам сүлжээ ашиглалтын үйл ажиллагаа, цахилгаан эрчим хүчний болзошгүй эрсдэлээс шалтгаалсан гэмтэл, саатлаас үүсэхээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх.

5.11. Улаанбаатар хотын ус хангамжийн дамжуулах, түгээх магистраль шугам сүлжээ, эх үүсвэр, дамжуулах станцуудыг батлагдсан "Хүйтний улиралд ажиллах горим тохируулга"-ын дагуу сүлжээний тохируулга, хэвийн ажиллагааг хангаж хэрэглэгчдийг тасралтгүй усаар хангах.

5.12. Зохион байгуулсан арга хэмжээний дүн, мэдээг 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын урьдчилан сэргийлэх сурталчилгаа хариуцсан мэргэжилтний [enkhmaanema4@gmail.com](mailto:enkhmaanema4@gmail.com), цахим хаягаар илтгэх хуудсаар ирүүлнэ.

#### **Зургаа. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал**

6.1. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон төрийн захиргааны байгууллага удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2. Нэгдсэн тайланг Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2021 оны 5 дугаар сарын 15-ны дотор танилцуулна. Тайлангийн хувийг Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд хүргүүлнэ.

6.3. Нэгдсэн арга хэмжээ явуулах зардлыг тухайн асуудлыг хариуцсан яам, агентлаг, аймаг, нийслэл санхүүжүүлнэ.

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**